

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/3/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.02.24 № 2/98

танай _____-ны № _____-т

Г _____ Г

**БАЯНХОНГОР СУМЫН
ЭРДЭНЭМАНДАЛ СУРГУУЛИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Л.ОНОНХҮҮ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2022 онд 71802 хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд 2,188,109.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,185,900.3 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 2,209.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 65,535.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Спортын төрөлжсөн сургалтын үйл ажиллагаанд тулгуурлан 2022 оны 3,4 дүгээр сард Бадминтоны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн, футзалын улсын аварга шалгаруулах тэмцээн, ширээний теннисний бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймаг, улсын холбоодтой хамтран зохион байгуулсан, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээгээр 15 багш 1-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн байна.

D/2023-A4 Alban toot.doc

005020392

Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас суурилуулсан интернэтийг ашиглах, холбогдох шийдвэрийн дагуу албан хаагчдын цалин хөлсийг үнэн зөв тооцох, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зэрэг зөвлөмжийг өгсөн нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 93.3 хувьтай тайлагнасныг дээд шатны байгууллагаас 93.1 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>321,529,082.68</u>	<u>360,103,232.72</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	64,535,446.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	64,535,446.19
3121	Төгрөг	00.00	64,535,446.19
31211	Төрийн сангийн харилцах	00.00	64,535,446.19
33	АВЛАГА	6,339,408.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	37,800.00	00.00
335	Бусад авлага	6,301,608.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,301,608.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	315,189,674.68	295,567,786.53
351	Түүхий эд материал	96,947,410.36	85,782,306.81
35110	Тусгай зориулалттай материал	77,401,430.36	75,259,756.81
35130	Эм боох материал	19,545,980.00	10,522,550.00
354	Хангамжийн материал	218,242,264.32	209,785,479.72
35410	Бичиг хэргийн материал	12,032,567.00	8,904,453.00
35420	Аж ахуйн материал	7,547,057.00	8,044,602.00
35450	Барилгын засварын материал	33,251,530.00	21,195,730.00
35460	Хүнсний материал	448,350.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	164,962,760.32	171,640,694.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,933,392,563.80</u>	<u>4,189,485,091.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,933,392,563.80	4,189,485,091.38
392	Биет хөрөнгө	3,297,942,563.80	3,543,710,091.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,384,670,267.36	3,614,856,157.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	-399,755,162.54	-533,593,545.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	298,435,311.22	490,144,333.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-197,520,373.51	-228,969,303.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	284,664,615.55	304,570,818.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	-149,117,255.28	-182,278,529.61
39217	Ном	76,565,161.00	78,980,161.00
393	Биет бус хөрөнгө	635,450,000.00	645,775,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	636,000,000.00	646,325,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,254,921,646.48</u>	<u>4,549,588,324.10</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,254,921,646.48</u>	<u>4,549,588,324.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,254,921,646.48	4,549,588,324.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,468,610,681.55	1,468,610,681.55
51101	Өмч: - төрийн	1,468,610,681.55	1,468,610,681.55
512	Хуримтлагдсан үр дүн	751,541,320.88	1,046,207,998.50
51210	Өмнөх үеийн үр дүн	751,541,320.88	751,541,320.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	294,666,677.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,034,769,644.05	2,034,769,644.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,254,921,646.48</u>	<u>4,549,588,324.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,464,886,304.80	3,251,823,494.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,014,810.80	442,572,034.06
120	Нийтлэг татварын бус орлого	64,014,810.80	442,572,034.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	6,033,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,543,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	490,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,361,494.00	2,809,251,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	2,112,740,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	2,112,740,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,803,510,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	173,395,594.00	131,471,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	173,395,594.00	131,471,460.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	423,965,900.00	565,039,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	423,965,900.00	565,039,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,513,362,998.73	2,957,156,816.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,513,362,998.73	2,957,156,816.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,318,157,283.48	2,696,872,298.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,456,323,319.00	1,623,886,231.60
210101	Үндсэн цалин	1,221,750,119.00	1,129,831,488.00
210102	Нэмэгдэл	145,256,200.00	397,544,971.60
210104	Урамшуулал	89,317,000.00	29,277,547.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	67,232,225.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	188,850,180.75	201,936,273.28
210201	Тэтгэврийн даатгал	132,344,570.75	139,634,964.31
210202	Тэтгэмжийн даатгал	14,685,253.00	16,406,115.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,714,602.00	12,956,571.61
210204	Ажилгүйдлийн даатгал	2,736,886.00	2,990,554.99
210205	Эрүүл мэндийн даатгал	27,368,869.00	29,948,066.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,965,900.00	481,304,192.00
210301	Гэрэл, цахилгаан	10,154,645.00	19,729,738.00
210302	Түлш, халаалт	357,096,223.00	372,716,576.00
210303	Цэвэр, бохир ус	55,715,032.00	88,857,878.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,453,474.00	77,210,736.71
210401	Бичиг хэрэг	1,638,400.00	13,523,231.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	1,127,875.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,652,843.00	5,675,257.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,256,595.00	6,683,311.00
210408	Бараа материал акталсны зардал	4,405,636.00	49,001,062.71
2105	Нормативт зардал	640,100.00	45,013,574.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	640,100.00	3,626,280.00
210502	Хоол, хүнс	00.00	41,387,294.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,097,070.00	18,055,800.00
210604	Урсгал засвар	24,097,070.00	18,055,800.00
2107	Томилолт, зочны зардал	950,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	950,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,372,477.00	13,317,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,532,600.00	5,671,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	239,877.00	7,646,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	201,504,762.73	236,147,890.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,708,880.00	33,148,397.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,696,100.00	4,550,907.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,099,782.73	198,448,586.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,205,715.25	260,284,517.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	194,744,169.00	258,074,932.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,435,000.00	124,301,864.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,236,069.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,935,100.00	127,471,460.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,138,000.00	6,301,608.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,209,585.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,209,585.93
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	461,546.25	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-48,476,693.93	294,666,677.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,400,871,494.00	2,815,284,760.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	6,033,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	6,033,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	6,033,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	5,543,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	490,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,400,871,494.00	2,809,251,460.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	2,112,740,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	2,112,740,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,803,510,000.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	173,395,594.00	131,471,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	173,395,594.00	131,471,460.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	423,965,900.00	565,039,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	423,965,900.00	565,039,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,364,218,494.00	2,694,394,313.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,364,218,494.00	2,694,394,313.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,168,564,428.75	2,440,859,753.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,455,556,299.75	1,621,893,530.00
210101	Үндсэн цалин	1,220,983,099.75	1,127,838,786.40
210102	Нэмэгдэл	145,256,200.00	397,544,971.60
210104	Урамшуулал	89,317,000.00	29,277,547.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	67,232,225.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,655,000.00	203,891,174.88
210201	Тэтгэврийн даатгал	140,574,100.00	138,994,468.21
210202	Тэтгэмжийн даатгал	12,426,100.00	16,448,491.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,925,400.00	13,041,893.20
210204	Ажилгүйдлийн даатгал	2,485,200.00	3,185,989.14
210205	Эрүүл мэндийн даатгал	24,244,200.00	32,220,332.42

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,965,900.00	481,304,192.00
210301	Гэрэл, цахилгаан	10,154,645.00	19,729,738.00
210302	Түлш, халаалт	357,096,223.00	372,716,576.00
210303	Цэвэр, бохир ус	55,715,032.00	88,857,878.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,014,067.00	00.00
210401	Бичиг хэрэг	2,193,950.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,652,843.00	00.00
210404	Ном, хэвлэл	69,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,597,974.00	00.00
2105	Нормативт зардал	4,142,500.00	41,387,294.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	640,100.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	41,387,294.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,502,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,702,600.00	6,000,000.00
210602	Тавилга	1,186,500.00	00.00
210604	Урсгал засвар	31,516,100.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	950,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	950,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,133,902.00	23,215,957.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,294,025.00	7,338,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	239,877.00	15,877,657.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,444,160.00	63,167,606.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,999,960.00	39,554,399.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,444,200.00	23,613,207.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,654,065.25	253,534,559.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,192,519.00	251,324,974.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,883,350.00	123,853,514.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	123,236,069.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,935,100.00	127,471,460.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,138,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,209,585.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,209,585.93
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	461,546.25	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	36,653,000.00	120,890,446.19
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,653,000.00	56,355,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,653,000.00	56,355,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,653,000.00	56,355,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,653,000.00	56,355,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-36,653,000.00	-56,355,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	64,535,446.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	64,535,446.19

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	751,541,320.88	4,254,921,646.48
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	751,541,320.88	4,254,921,646.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	751,541,320.88	4,254,921,646.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	294,666,677.62	294,666,677.62
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,468,610,681.55	2,034,769,644.05	1,046,207,998.50	4,549,588,324.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн үзүүлэлт	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,683,323,300.00	2,616,578,267.88	66,745,032.12	97.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,683,323,300.00	2,616,578,267.88	66,745,032.12	97.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,553,188,100.00	2,492,724,753.88	60,463,346.12	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,644,035,800.00	1,621,893,530.00	22,142,270.00	98.7
210101	Үндсэн цалин	1,194,365,200.00	1,127,838,786.40	66,526,413.60	94.4
210102	Нэмэгдэл	352,415,900.00	397,544,971.60	(45,129,071.60)	112.8
210104	Урамшуулал	29,988,300.00	29,277,547.00	710,753.00	97.6
210105	Гэрээт ажлын хөлс	67,266,400.00	67,232,225.00	34,175.00	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,629,100.00	203,891,174.88	1,737,925.12	99.2
210201	Тэтгэврийн даатгал	139,900,000.00	138,994,468.21	905,531.79	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	16,432,500.00	16,448,491.91	(15,991.91)	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,145,700.00	13,041,893.20	103,806.80	99.2
210204	Ажилгүйдлийн даатгал	3,286,400.00	3,185,989.14	100,410.86	96.9
210205	Эрүүл мэндийн даатгал	32,864,500.00	32,220,332.42	644,167.58	98.0

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	483,240,400.00	481,304,192.00	1,936,208.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	20,417,500.00	19,729,738.00	687,762.00	96.6
210302	Түлш, халаалт	373,039,300.00	372,716,576.00	322,724.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	89,783,600.00	88,857,878.00	925,722.00	99.0
2105	Нормативт зардал	58,032,500.00	41,387,294.00	16,645,206.00	71.3
210502	Хоол, хүнс	58,032,500.00	41,387,294.00	16,645,206.00	71.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,425,800.00	21,420,957.00	4,843.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,543,300.00	5,543,300.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,882,500.00	15,877,657.00	4,843.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134824500.00	116827606.00	17,996,894.00	86.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,000,800.00	93,004,399.00	17,996,401.00	83.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,823,700.00	23,823,207.00	493.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130135200.00	123853514.00	6,281,686.00	95.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	130,135,200.00	123,853,514.00	6,281,686.00	95.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	130,135,200.00	123,853,514.00	6,281,686.00	95.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,683,323,300.00	2,681,113,714.07	2,209,585.93	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,112,740,200.00	2,112,740,200.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,112,740,200.00	2,112,740,200.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	565,039,800.00	562,830,214.07	2,209,585.93	99.6
132001	Орон нутгийн төсвөөс	565,039,800.00	562,830,214.07	2,209,585.93	99.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,543,300.00	5,543,300.00	-	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,543,300.00	5,543,300.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	122	118	4	96.7
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	95	91	4	95.8
620003	Үйлчлэх ажилтан	26	26	-	100.0
620004	Гэрээт ажилтан	0	0	0	0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,236	1,062	174	85.9
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,236	1,062	174	85.9
630001	Төрийн өмчит ЕБС	1,236	1,062	174	85.9
630002	Хувийн ЕБС	00	00	0	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	122	118	4	96.7
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	84	80	4	95.2
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1	1	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	36	36	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	131,471,460.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	131,471,460.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,471,460.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	127,471,460.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	127,471,460.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	131,471,460.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,471,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,471,460.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургууль нь "Суралцагч нэг бүрийг хичээл сургалтын хоцрогдолгүй сургаж, сургалтын бүхий л орчин нөхцөлд ажиллаж, сурч боловсрох таатай орчныг бүрдүүлэх" эрхэм зорилготой тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захиргаа аж ахуй, Нийгмийн ухаан, Байгалийн ухаан, Бага ангийн заах аргын нэгдэл гэсэн бүтэц зохион байгуулалттай 118 орон тоотой, 1062 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Л.Ононхүү, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Янжмаа нар зурж, аж ахуйн нярваар П.Отгонжаргал, хүнсний нярваар 11-12 сард Б.Билэгсайхан нар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;
- Төрийн албаны зөвлөлийн 2022.11.14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор бүх албан хаагчдын хувийн хэрэг шинэчилсэн;
- Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор хичээл сургалтын үйл ажиллагаа, багш ажиллагсдын тасралтгүй хөгжлийг дэмжих, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлыг тус тус хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг томилсон;
- БШУС-ын 2022.05.12-ны өдрийн 170 дугаар тушаалын дагуу 5 ажлын хэсгийг байгуулсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 294,666.7 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	64,535.40	64,535.40
Авлага	6,339.40	-	(6,339.40)
Бараа материал	315,189.60	295,567.80	(19,621.80)
Үндсэн хөрөнгө	3,933,392.60	4,189,485.10	256,092.50
Нийт хөрөнгө	4,254,921.60	4,549,588.30	294,666.70
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4254921.60	4,549,588.30	294,666.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,254,921.60	4,549,588.30	294,666.70

Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд хүүхэд өдрийн гүйцэтгэлээс шалтгаалж үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны зардал, орон тоо 122 батлагдаж, 4 багш Баянхонгор сумын 5 дугаар сургууль руу шилжиж, гүйцэтгэлээр 118 орон тоогоор ажилласнаас цалингийн зардал, цахим дэлгүүрт захиалсан үндсэн хөрөнгө ирээгүйгээс хүүхдэд ээлтэй сургалтын орчин зардлаас хэмнэгдсэн зэргээс шалтгаалж, оны эцэст харилцах дансанд 64,535.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Тус сургуульд ажиллаж байгаад өндөр настын тэтгэвэрт гарсан 4 багшид олгосон тэтгэмжтэй холбоотой 6,310.6 мянган төгрөгийн өмнөх оны авлагыг Баянхонгор аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах салбар зөвлөлд албан бичиг хүргүүлж, тухайн иргэд мөнгөн тэтгэмжийг буцаан төлөх үндэслэлгүй гэж ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн сургуулийн захирлын 2022.05.25-ны өдрийн А/27 тоот тушаалын дагуу тус авлагыг хаажээ.

Сургуулийн захирлын 2022.06.16-ны өдрийн А/31, 2022.12.16-ны өдрийн А/67 дугаар тушаалаар нийт 49,001.1 мянган төгрөгийн бараа материал акталснаас өмнөх оноос бараа материал буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн хөрөнгөөр 56,355.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 121,560.8 мянга, НҮБ-ийн Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар 117,461.1 мянга, улсын төвийн хөрөнгө оруулалтаар 148,839.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тайланд онд нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 294,666.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,046,207.9 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 294,666.7 мянган төгрөгөөр нэмэгдэн 4,549,588.3 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,940,266.1 мянган төгрөгөөр төлөвлөж, 2021.07.23-ны өдөр аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үйл ажиллагааны зардлыг 589,496.3 мянган төгрөгөөр хасаж, 2,350,769.8 мянган төгрөгөөр баталсан нь орон тоог өмнөх оноос 10-аар нэмэгдүүлэхээр төлөвлөснийг батлаагүй, эд хогшил худалдан авах болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг батлаагүйтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг дээд шатны байгууллагаас 2022 оны 5 дугаар сард төсвийг цалингийн шатлал нэмэгдсэнтэй холбоотой 183,477.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 9 дүгээр сард гэрээт ажлын хөлсийг бууруулж, хоолны зардлыг нэмэгдүүлсэн ба нийт дүнгээрээ төсвийг 27,712.0 мянган төгрөгөөр бууруулжээ. Цалин, түүнтэй холбоотой зардал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг нэмэгдүүлснээс 10 дугаар сард төсвийг 83,343.3 мянга, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 25,454.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 71,930.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс 11 дүгээр сард төсвийг 93,444.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,683,323.3 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 2,112,740.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 2,048,204.8 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 64,535.4 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 565,039.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.6 хувь буюу 562,830.2 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 2,209.6 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	6,353.00	6,352.93	0.07	100.0
2	80312 Сургалт семинар	3,176.50	3,176.00	0.50	100.0
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	7,305.90	7,303.00	2.90	100.0
4	81801 Үдийн цай хөтөлбөр	130,135.20	123,853.51	6,281.69	95.2
5	81806 Дотуур байрны үйлчилгээ	72,997.60	56,352.39	16,645.21	77.2
6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	71,930.00	53,940.00	17,990.00	75.0
7	81823 Боловсролын байгууллагын багш	14,294.20	14,293.08	1.13	100.0
8	81834 Боловсролын стандарт, сургалтын	1,623,070.10	1,621,142.93	1,927.17	99.9
9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	183,477.70	161,790.91	21,686.79	88.2
10	81848 Сурах бичгийн түрээс	5,543.30	5,543.30	-	100.0
11	80112 Нийтлэг үйлчилгээ	565,039.80	562,830.21	2,209.59	99.6
ДҮН		2,683,323.30	2,616,578.27	66,745.03	97.5

Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 5 жилд нэг удаа олгох тэтгэмжийн санхүүжилтийн 127,471.5 мянган төгрөгийг сургуулийн захирлын 2022.02.28-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар олгосон, гүнзгийрүүлсэн ангийн сургалтын төлбөрийн орлогын 4,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснийг багш нараас санал авсны үндсэн дээр сургалтын хэрэглэгдэхүүн авахад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас суурилуулсан интернэтийг ашиглах, холбогдох шийдвэрийг үндэслэн, албан хаагчдын цалин хөлсийг үнэн зөв олгох, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст гэрээг нөхөн байршуулах сэргийлэх зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.12.08-ны өдрийн 265 дугаар албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 2,764,006.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 41,460.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 29,022.1 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээд шатны байгууллагаас чиглэл заавар ирээгүй, тайлант онд цалин, шимтгэлийн зардлыг 23,880.2 мянга, тогтмол зардлыг 1,936.2 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 16,645.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 17,996.9 мянга, үдийн цайны зардлыг 6,281.7 мянган төгрөгөөр хэмнэж, оны эцэст 2,209.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, зарцуулаагүй үлдэгдэл харилцах дансанд үлдэгдлээр байна.

Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн тогтмол зардлын гүйцэтгэл өмнөх оноос 58,338.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сургуулийн дотуур байр шинээр ашиглалтад орсонтой холбоотой халаалтын зардал сард 9,233.4 мянган төгрөг төлж, гэрэл цахилгаан болон цэвэр бохир усны тариф 2022 онд нэмэгдсэнтэй холбоотой байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,741,462.6 мянган төгрөгийн 59 гүйлгээ, зарлагын 692,949.7 мянган төгрөгийн 39 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 643,738.5 мянган төгрөгийн 23 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин тайлант онд аж ахуйн нэгж байгууллагуудтай 644,427.4 мянган төгрөгийн 26 гэрээ байгуулснаас шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 23,194.0 мянган төгрөгийн 5 гэрээг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст гэрээг бүрэн байршуулах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, менежментийн захидлаар 6,301.6 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	6,301.6	3	6,301.6	100.0
Нийт дүн	3	6,301.6	3	6,301.6	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн 2022.05.30-ны өдрийн 124 дүгээр албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2022.05.30-ны өдөр 124 дүгээр албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан сургуулийн 2 давхар 20 тасагтай 100 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай дотуур байрыг 2021 оны 6 дугаар сард ашиглалтад авсан боловч холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүйгээс тус хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгээгүй байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

Засгийн газрын 2019 оны 450 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолын 4-т Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БСУШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 онд 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хүүхэд өдрийн гүйцэтгэлд хяналт тавьсан, дотуур байранд төлөвлөснөөс хүүхэд дутуу хүлээн авсны улмаас дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 16,645.2 мянга, үдийн хоолны хөтөлбөрийн зардлыг 6,281.7 мянган хэмнэсэн байхад оны эцэст төсөвт төвлөрүүлэлгүй, харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж, Эрдэнэмандал сургууль, аймгийн Орон нутгийн өмчийн газар 2022.10.06-ны өдөр орон нутгийн өөрийн өмчийн ашиглалтын 01 тоот гэрээг байгуулж, Эрдэнэмандал ахлах сургуулийн дотуур байрны 7 өрөөнд Политехникийн коллежийн 60 оюутныг байрлуулж, эд хөрөнгийн ашиглалтын зардалд өдөрт 267.0 мянган төгрөгөөр тооцож, гэрээг 2022.10.06-2023.06.10-ны өдрийг хүртэлх хугацаанд байгуулсан байна.

Политехникийн коллеж эд хөрөнгийн ашиглалтын зардлыг төлөөгүй, 11 дүгээр сард төсвийн тодотголоор орон нутгийн төсвөөс гэрэл цахилгааны зардалд 9,171.0 мянга, цэвэр, бохир усны зардалд 16,283.6 мянга, нийт 25,454.6 мянган төгрөгөөр тогтмол зардлыг нэмэгдүүлэн тодотгож өгсөн байна. Эрдэнэмандал сургууль нь цаашид өөрийн сургуулийн хүүхдүүдийг дотуур байрандаа бүрэн авч үйл ажиллагаагаа явуулах нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,451.9 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд менежментийн захидлаар зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: БШУС-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх албанаас ирүүлсэн аудит хийх чиглэлийн 5-д "Боловсролын мэдээллийн технологийн төв" улсын төсвийн үйлдвэрийн газраас бүх сургууль, цэцэрлэгийн интернэтийн төлбөрийг төлсөн, интернэтийн төлбөрийг давхардуулан төлж, үр ашиггүй зардал гаргасан байх" асуудлыг ирүүлснийг тодруулан шалгахад тус интернэтийн хурд, хүчин чадал шаардлага хангахгүйгээс ашиглах боломжгүй гэсэн шалтгаанаар 2022 онд Монголын цахилгаан холбоо ТӨХК-д интернэтийн төлбөрт 5,157.3 мянган төгрөгийг давхардуулан төлсөн байна.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн технологийн төв" улсын төсвийн үйлдвэрийн газраас суурилуулсан интернэтийг бүрэн ашиглаж, бусад байгууллагуудад интернэтийн төлбөрийг давхардуулан төлөхгүй байх

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сургуулийн захирлын 2022.03.14-ны өдрийн Б/16, Б/17, Б/18 дугаар тушаалаар 3 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байхад сургуулийн нягтлан бодогч эдгээр албан хаагчдын цалинг 20 хувиар бууруулан тооцож, цалинг 294.6 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох шийдвэрийг үндэслэн, албан хаагчдын цалин хөлсийг үнэн зөв олгож байх

3. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд аж ахуйн нэгж байгууллагуудтай 644,427.4 мянган төгрөгийн 26 гэрээ байгуулснаас шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 23,194.0 мянган төгрөгийн 5 гэрээг байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст гэрээг тухай бүр байршуулах, орхигдуулсан гэрээг нөхөн мэдээлэх

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БШУС-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх албанаас ирүүлсэн аудит хийх чиглэлийн 5-д "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ-аас бүх сургууль, цэцэрлэгийн интернэтийн төлбөрийг төлсөн, интернэтийн төлбөрийг давхардуулан төлж, үр ашиггүй зардал гаргасан байх" асуудлыг ирүүлснийг тодруулан шалгахад тус интернэтийн хурд, хүчин чадал шаардлага хангахгүйгээс ашиглах боломжгүй тул 2022 онд Монголын цахилгаан холбоо ТӨХК-д интернэтийн төлбөрт 5,157.3 мянган төгрөгийг давхардуулан төлсөн байна.	1	5,157.3					1	5,157.3				
Сургуулийн захирлын 2022.03.14-ны өдрийн Б/16, Б/17, Б/18 дугаар тушаалаар 3 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байхад сургуулийн нягтлан бодогч эдгээр албан хаагчдын цалинг 20 хувиар бууруулан тооцож, цалинг 294.6 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.	1	294.6					1	294.6				
Дүн	2	5,451.9	0	-	0	-	2	5,451.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд аж ахуйн нэгж байгууллагуудтай 644,427.4 мянган төгрөгийн 26 гэрээ байгуулснаас шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 23,194.0 мянган төгрөгийн 5 гэрээг байршуулаагүй байна.	1	0					1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	0	0	0	0	0	1	0

---oOo---